



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД  
Н.ТАВИНБЭХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛТ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2021.02.26 № 05

Асуулт тавих тухай

Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "...Томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ...", мөн "...Орон нутгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулна..." гэж тус тус заасан билээ.

Энэ хүрээнд баруун бүсийн томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой Хөшөөтийн уурхайг түшиглэн нийт 12 тэрбум төгрөгийн өртөг бүхий сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах төрийн бодлого шийдвэр гарч, 2021 оны улсын төсөвт 2 тэрбум төгрөг суулгасан.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд баруун бүс, түүний дотор Ховд хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор улсын төсөвт суулгасан дээрх хөрөнгийг Эрчим хүчний яам хэрхэн хурдтай, чанартай, зөв зохион байгуулж, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг ямар хугацаанд хийхээр төлөвлөж байгааг тодруулах үүднээс дараах асуултыг Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэсэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах ажлыг хэдийнээс эхлүүлж, эхний ээлжийг хэзээ ашиглалтад оруулж, сайжруулсан түлшийг хэзээнээс хэрэглэгчдийн гар дээр хүргэхээр төлөвлөж байгаа;
2. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр нь ямар хүчин чадалтай, жилдээ хэдэн тонн түлш үйлдвэрлэх хүчин чадалтай байх талаарх тооцоо, судалгаа;
3. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулагдсанаар аймгийн төвүүд болон сум, суурин газруудын агаарын бохирдлыг хэдэн хувь бууруулах, иргэдийг шахмал түлшний хомсдолд оруулахгүй хэрхэн хэрэгцээг нь хангах боломж байгаа талаар тодорхой хариулт бэлдэж өгнө үү.

2020000099

Энэхүү асуултын хариуг Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт заасан хугацаанд холбогдох тооцоо, судалгааны хамт ирүүлж, Байнгын хорооны хуралдаанд сонсгоно уу.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



С.БЯМБАЦОГТ

2020090699